



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх,
хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.4, 15.12.9, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагуудын нэрсийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн эрх сэргээсэн байгууллагын нэрийг гуравдугаар, тусгай зөвшөөрлийн эрх хүчингүй болгосон байгууллагын нэрийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан, эрх сэргээсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа /-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080043

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 25 өдрийн
17 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР,
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА


№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Дарви Фарм ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Ламор ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, лабораторийн урвалж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	АНТС ХХК	тоног төхөөрөмж, лабораторийн урвалж, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Наномед ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, лабораторийн урвалж, оношлуур, ахуйн хортон шавьж, мэрэгч устгах, ариутгал халдваргүйтгэлийн бодис импортлох /өөрийн хэрэгцээнд/	3 жил
5	Баса ХХК	шүдний эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Эрүүл мэнд интернэшнл ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
7	Голден фүжи ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
8	Архон ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил
9	Уламжлалт идээ ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
10	Мон Эйч Пи Онош ХХК	урсазлыг түргэвчилсэн оношлуур үйлдвэрлэх	3 жил
11	Солонго хараа ХХК	эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох /өөрийн хэрэгцээнд/	3 жил
12	Нью Терравокс ХХК	эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил
13	Түмэн гэгээ ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 04 сарын 15 өдрийн
17 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА


№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Найрамдал эмнэлэг ХХК-ний "Найрамдал" эмнэлэг	дотор, мэдрэлийн тусламж үйлчилгээ	3 жил
2	Эффект ХХК	лабораторийн урвалж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Монополе фармацевтикаль ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх	3 жил
4	Азифарм ХХК	эм үйлдвэрлэх	3 жил
5	Мөнхийн тун ХХК	вакцин, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн багаж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Ай он центр ХХК	нүдний эм импортлох, ханган нийлүүлэх	3 жил
7	Сүвэн уул ХХК	эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил
8	Их шүүдэргэнэ импорт ХХК	протез, эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 15 өдрийн
11 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СЭРГЭЭСЭН БАЙГУУЛЛАГЫН НЭР,
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Арцны жимс ХХК	эм үйлдвэрлэх	3 жил



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	ЭХ-06/23/3260	БМТД ХХК	Жирэн клиник-эмэгтэйчүүд, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ